



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/348

Мандалговь

Ашигт малтмал тээвэрлэлтийн
чиглэл батлах тухай

Авто замын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, Авто тээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 09 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гурвансайхан сумын нутагт орших Цагаан дэлийн жоншны уурхайгаас Говьсүмбэр аймаг хүртлэх 210 км ашигт малтмал тээвэрлэлтийн авто замын чиглэлийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан чиглэлийн дагуух орон нутгийн чанартай авто замыг арчилж хамгаалан, замын тэмдэглэгээ байрлуулж, маршрутын дагуу тээвэрлэлт явуулж байхыг "Мирайфлюорид" ХХК-ний захирал (Цегельник.В.П) -д үүрэг болгосугай.

Гурав. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хүрээнд батлагдсан маршрутын дагуу тээвэрлэлт явуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Авто тээврийн төв (Ц.Бямбацогт), Цагдаагийн газар (О.Амарсанаа), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга (Н.Гантулга) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190989

Аймгийн Засаг даргын 2019 оны
10 сарын 01 өдрийн 1/348 дугаар
захирамжийн хавсралт

ГУРВАНСАЙХАН СУМЫН "ЦАГААН ДЭЛ"-ИЙН ЖОНШНЫ УУРХАЙГААС
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЧОЙР ХҮРТЭЛХ 210 КМ АВТО ЗАМЫН ЧИГЛЭЛИЙН
СОЛБИЦОЛ

| № | Байршил | Уртраг | Өргөрөг |
|---|----------------------|--------------------|--------------------|
| 1 | Цагаан дэлийн уурхай | 106° 49' 4.7424" | 45° 23' 53.298528" |
| 2 | Гурвансайхан сум | 107° 2' 38.99976" | 45° 29' 13.627104" |
| 3 | Элгэн ус | 107° 26' 45.72168" | 45° 41' 35.469888" |
| 4 | | 107° 44' 14.15436" | 45° 45' 28.57662" |
| 5 | | 108° 5' 40.09668" | 45° 58' 12.4563" |
| 6 | | 108° 13' 55.09596" | 46° 12' 36.722808" |
| 7 | Чойр | 108° 22' 21.66996" | 46° 24' 41.461668" |